



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/209

Өмнөдэлгэр сум

**Ойн цэвэрлэгээний арга хэмжээг
хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.2 дахь заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/78 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр тус сумын Өлийн даваа гэх газар буюу ойн сангийн 739 дүгээр хэсэглэлийн 16, 20, 23, 25, 28 дугаар ялгарал дахь 100 га талбайд ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг “Зоос булаг” ХХК-аар гүйцэтгүүлсүгэй.

2.Ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх талбайд цэвэрлэгээний ажил, цэвэрлэгээний огтлолтын арга хэмжээг хамтад хэрэгжүүлэх мод бэлтгэлийн талбай тусгаарлалт хийх, тухайн талбайгаас гарах нөөцийг тодорхойлох, нөөц ашиглах эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох, тухайн талбайд өөрийн хөрөнгийн нөхөн сэргээх талбайн хэмжээг мод бэлтгэх гэрээнд тусган, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулахыг Хэнтий шинэс сум дундын ойн ангийн дарга (Б.Давхарбаяр)-т даалгасугай.

3.Ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх ажилд байнгын хяналт тавьж ажиллахыг байгаль хамгаалагч (С.Ууганбаяр), мод бэлтгэх эрхийн бичиг, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (Т.Чинхуяг) нарт тус тус хариуцуулсугай.



Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj